



**НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН
ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ
АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗАР**

**2019 ОНЫ ОНЦЛОХ
АЖЛУУД**

**УЛААНБААТАР ХОТ
2019 он**

НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗАР
2019 ОНЫ 3-Р УЛИРЛЫН БАЙДЛААР ХИЙЖ ГҮЙЦЭТГЭСЭН ТОМООХОН
АЖЛЫН ТАЙЛАН

2019 оны 9 дугаар сарын 25-ны өдөр

Улаанбаатар хот

Нэг. Жуулчдыг татах болон аялал жуулчлалын салбарын нийслэлийн эдийн засаг, нийгмийн хөгжилд үзүүлэх нөлөөллийг зохистой түвшинд хүргэхэд чиглэсэн үйл ажиллагаа явуулах чиглэлээр:

“АЙ-ТИ-БИ БЕРЛИН 2019” ОЛОН УЛСЫН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН
ҮЗЭСГЭЛЭН

Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын Берлин хотод 2019 оны 03 дугаар сарын 06-10-ны өдрүүдэд зохион байгуулагдсан “Ай-Ти-Би Берлин 2019” олон улсын аялал жуулчлалын үзэсгэлэнд нийслэлийн Засаг даргын 2019 оны А/120 тоот захирамжийн дагуу нийслэлийн төлөөлөгчид, уран бүтээлчдийн нийт 10 хүний бүрэлдэхүүнтэй баг болон БОАЖЯ, МИАТ ХК, Монгол Улсаас ХБНГУ-д суугаа Элчин сайдын яам болон аялал жуулчлалын тур оператор компаниуд оролцож Улаанбаатар хотыг сурталчлан оролцсон. Үзэсгэлэнгийн үеэр тус газраас А4 хэмжээтэй герман хэл дээрх “Улаанбаатар-Таны Монголд хүрэх үүд хаалга” сэтгүүлийг 1500 ширхгийг тарааж ажиллав. Тус үзэсгэлэнд 181 орны 10,000 гаруй аялал жуулчлалын бизнес эрхэлдэг аж ахуйн нэгж, байгууллагууд оролцсон ба 170,000 хүн ирж сонирхсон.





“БАЙКАЛ ТҮР” ОЛОН УЛСЫН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ҮЗЭСГЭЛЭН

ОХУ-ын Эрхүү хотод хотод жил бүр зохион байгуулагддаг “Байкалтур” олон улсын аялал жуулчлалын үзэсгэлэнд нийслэлийн Засаг даргын 2019 оны А/216 тоот захирамжийн дагуу 03 дугаар сарын 28-30-ны өдрүүдэд оролцов. Үзэсгэлэнд БОАЖЯ, Нийслэлийн Аялал жуулчлалын газар, Улаанбаатар чуулга, Хөвсгөл аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газар, УБТЗ ХНН, Улаанбаатар аялал жуулчлалын холбоо, Улаанбаатар телевиз болон аялал жуулчлалын 10 компаниуд нийт 40 гаруй хүний бүрэлдэхүүнтэй оролцож Улаанбаатар хотын аялал жуулчлалын мэдээллийг өгч, 80 нүүр бүхий орос хэл дээрх Улаанбаатар сэтгүүл, газрын зураг, хөтөч номыг түгээж ажилласан. Үзэсгэлэнд ОХУ, БНХАУ, БНСУ-ын нийт 100 гаруй аялал жуулчлалын байгууллагууд оролцож 10 000 гаруй хүн сонирхсон байна. Монгол Улсын төлөөлөл үзэсгэлэнд оролцогчдод олгодог тэргүүн шагнал болох “Золотая награда” цомыг өргөмжлөлийн хамт хүртэв.






“АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ БА АЖИЛ ЭРХЛЭЛТ-2019” ХӨДӨЛМӨРИЙН ЯАРМАГ

“Аялал жуулчлал ба ажил эрхлэлт-2019” хөдөлмөрийн яармагийг 03 дугаар сарын 29-31-ний өдрүүдэд “ITM” олон улсын аялал жуулчлалын үзэсгэлэнгийн үеэр “Мишээл экспо”-д зохион байгуулсан. Арга хэмжээг Нийслэлийн Хөдөлмөр эрхлэлтийн газар, “Монголын Аялал жуулчлалын холбоо” ТББ-тай хамтран 11 дэх жилдээ зохион байгуулсан ба зочид буудал, зоогийн газар, жуулчны бааз, аялал жуулчлалын чиглэлээр 600 гаруй нээлттэй ажлын байр зарласан. Хөдөлмөрийн яармагт давхардсан тоогоор 1000 гаруй хүн оролцож, яармагийн үеэр 210 иргэдийг нийт 60 ажил олгогч компанид зуучлав.





“УЛААНБААТАР” ҮНДЭСНИЙ АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ҮЗЭСГЭЛЭН

Нийслэлийн Аялал жуулчлалын газар, Байгаль орчин, аялал жуулчлалын яам, Улаанбаатар Аялал жуулчлалын холбоотой хамтран “Улаанбаатар” үндэсний аялал жуулчлалын үзэсгэлэнг 2019 оны 05 дугаар сарын 24-26-ны өдрүүдэд 5 дахь жилдээ “Хоггүй байгалийн төлөө” уриан доор Мишээл экспо төвд зохион байгуулсан. Үзэсгэлэнгийн түнш улсаар БНСУ, түнш аймгаар Дорнод аймаг оролцов. Үзэсгэлэнд 86 байгууллага оролцож дотоод, гадаадын 6000 гаруй иргэд, жуулчдад аялах газрын мэдээлэл, үнэ болон бүтээгдэхүүн үйлчилгээний танилцуулга, гадаадад аялуулагч тур оператор компаниудын бүтээгдэхүүн, харилцаа холбоо, аяллын даатгалын иж бүрэн үйлчилгээтэй танилцах, аялал жуулчлалын шинэ чиг хандлагын талаар мэдээлэл өгч ажилласан. Мөн БНСУ-аас эрүүл мэндийн аялал жуулчлалын компаниуд эмчийн үзлэг, оношилгоог үнэ төлбөргүй хийж зөвлөгөө өгсөн.



УЛААНБААТАРЫН ӨВЛИЙН НААДАМ АРГА ХЭМЖЭЭ

Нийслэлийн Засаг даргын 2019 оны А/67 дугаар захирамжийн дагуу “Улаанбаатарын өвлийн наадам-2019” арга хэмжээг 02 дугаар сарын 16, 17-ны өдөр “Скай резорт” цанын баазад зохион байгуулав. Тусгай сонирхлын аялал жуулчлалыг хөгжүүлэх, өвлийн улирлын уламжлалт болон орчин үеийн экстрим спортыг түгээн дэлгэрүүлэх, жуулчны улирлын хугацааг уртасгах, өвлийн улиралд Улаанбаатар хотод ирсэн жуулчдын сонирхлыг татах арга хэмжээний тоог нэмэгдүүлэх зорилготой тус арга хэмжээнд ОХУ-ын Буриад улсаас 10, Тува улсаас 10, БНХАУ-ын ӨМӨЗО-ноос 20, нийт 40 тамирчин хүрэлцэн ирж, мөсөн сурын улсын аварга шалгаруулах тэмцээнд оролцлоо. Мөн ОХУ-ын Эрхүү мужийн “АИСТ ТВ” болон БНХАУ-ын ӨМӨЗО-ны “Монгол Одон ТВ”-ийн хэвлэл мэдээллийн 4 төлөөлөгч ирж сурвалжлав. “Улаанбаатарын өвлийн наадам-2019” арга хэмжээнд нийт 12 аймгийн 600 гаруй тамирчин, Улаанбаатар хотын 300 гаруй тамирчин нийт 900 гаруй тамирчин оролцож, наадмыг гадаад, дотоодын 9,000 гаруй хүн сонирхсон байна.



“БҮРГЭДИЙН БАЯР-2019” АРГА ХЭМЖЭЭ

Жуулчлалын улирлын хугацааг уртасгах, тусгай сонирхлын аялал жуулчлалыг хөгжүүлэх, төв Азийн нүүдэлчин ард түмний ёс зан заншил, өв уламжлалаар дамжуулан гадаад, дотоодын жуулчдыг татах, нийслэлийн иргэдийн амралт, чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх зорилгоор 03-р сарын 03, 04-ний өдөр Хан-Уул дүүргийн 8-р хороо, Богд хан уулын Жаргалантын аманд “Чингис хааны хүрээ” аялал жуулчлалын цогцолборт “Бүргэдийн баяр-2019” арга хэмжээг зохион байгуулсан. Арга хэмжээг Байгаль орчин, аялал жуулчлалын яам, Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, Монголын Бүргэдчид холбоо ТББ, Улаанбаатар аялал жуулчлалын холбоо ТББ-уудтай хамтран зохион байгуулав. Нийслэлийн Засаг даргын 2019 оны А/86 дугаар захирамжийн хүрээнд “Бүргэдийн

баяр” арга хэмжээнд оролцохоор ирсэн нийт 20 бүргэдчинг Баян-Өлгийгөөс Улаанбаатар, Улаанбаатараас Баян-Өлгийн чиглэлийн хоёр талын онгоцны тийзийн үнэ болох 11 134 000 төгрөгийн дэмжлэгийг үзүүлэн ажилласан. Бүргэдийн баярт АНУ, Кувейт, Турк, Казакстан зэрэг улсын Элчин сайдын яамдуудын төлөөллүүд, гадаад, дотоодын иргэд, жуулчид, нийт 5000 орчим хүн үзэж сонирхсон. Үүнээс 200 гаруй нь гадаадын иргэд байсан.



ТАЛЫН САЛХИ-2019 АРГА ХЭМЖЭЭ

“Талын салхи” олон улсын мото наадмыг нийслэлийн Засаг даргын 2019 оны А/501 дүгээр захирамжаар “Монголын Чопперчин ахан дүүс” ТББ-тай хамтран 6 дугаар сарын 08-09-ний өдрүүдэд Улаанбаатар хот-“Цонжин Болдог” Чингис хааны хөшөөт цогцолбор чиглэлд зохион байгууллаа. Монгол, БНХАУ, ОХУ-ын Цайны замын хүрээнд ОХУ-аас 15 клубын 120, БНХАУ-аас 5 клубын 40, Энэтхэг, Япон, Европын холбооны улсаас 20 гаруй, дотоодын 20 клубын 600 гаруй мото сонирхогч, нийт 800 гаруй тамирчин оролцлоо. Жанжин Д.Сүхбаатарын талбайн нээлт болон “Цонжин

Болдог” Чингис хааны хөшөөт цогцолборт болсон урлаг, соёлын арга хэмжээг нийт 5000 гаруй иргэд, жуулчин үзэж сонирхсон байна.



ДЭЭЛТЭЙ МОНГОЛ НААДАМ

Нийслэлийн Засаг даргын А/665 захирамжийн дагуу Монголчуудын уламжлалт соёл, үндэстэн ястны дээл хувцас, эд хэрэглэл, ардын урлагийн биет болон биет бус өвийг сурталчлан таниулах, түгээн дэлгэрүүлэх зорилготой “Дээлтэй Монгол наадам-2019” арга хэмжээг жанжин Д.Сүхбаатарын талбайд 2019 оны 07 дугаар сарын 10-ны өдөр зохион байгууллаа. Арга хэмжээг зохион байгуулахдаа үндэсний дээл хувцасны загварын үзүүлбэр, дүүрэг, аж ахуй нэгж, байгууллага иргэдийн парад, үндэсний уламжлалт зан үйл, ёс заншил, дээл хувцас, эдлэл хэрэглэл, тоглоом наадгай, гар урлал зэргийг үзүүлсэн гэр хотхон, мөн үндэсний дээл хувцас, эдлэл хэрэглэлийн үзэсгэлэн худалдаа зэрэг үйл ажиллагааг явууллаа.

Үндэсний дээл хувцастай шилдэг эрэгтэй, эмэгтэй, хүүхэд, гэр бүл, гадаад эрэгтэй эмэгтэй оролцогч, аж ахуй нэгж, дүүргийг тодруулж урамшууллаа.

Арга хэмжээний парадад нийт 6 дүүрэг, 8 аж ахуй нэгжийн 1500 гаруй хүн жагсаж, тайз дэлгэцийн үндэсний хувцасны загварын үзүүлбэрт 55 хүүхэд, 60 гаруй загвар өмсөгчид болон 30 гаруй хүн урлаг соёлын тоглолт хийж, нийт 7000 гаруй хүн үзэж сонирхсоноос 500 гаруй нь гадаадын жуулчид байсан.

Энэ жил ОХУ-ын Бүгд Найрамдах Тува улсын Эдегей хамтлагийн 30 гаруй хүний бүрэлдэхүүнтэй уран бүтээлчид Монгол туургатны Тува үндэсний хувцасны 3 коллекц үзүүлбэр, БНХАУ-ын ӨМӨЗО-ын Алша аймгийн Эзнээ хошууны Торгууд хувцас заслын компанийн 14 төлөөлөгчид Торгууд угсаатны хувцасны загварын үзүүлбэр, “Монгол үндэстний гоо бүсгүй” шалгаруулах тэмцээнд оролцогч Монгол туургатан улсуудаас бүрдсэн 16 миссүүдийн загварын үзүүлбэр үзүүлж Монгол туургатан улсуудыг хамтруулсанаараа энэ удаагийн наадам онцлог байлаа.





**“Улаанбаатар хотыг сурталчлах аялал жуулчлалын өдөрлөг”
арга хэмжээг БНХАУ-ын ӨМӨЗО-ны Ордос болон
Улаанцав хотуудад зохион байгуулав.**

Нийслэлийн Засаг даргын 2019 оны 06 дугаар сарын 13-ны өдрийн А/581 дугаар захирамжийн дагуу БНХАУ-ын ӨМӨЗО-ны Ордос болон Улаанцав хотуудад Улаанбаатар хот болон Монгол улсын аялал жуулчлал, соёл урлагийг сурталчилсан “Улаанбаатар хотыг сурталчлах аялал жуулчлалын өдөрлөг” арга хэмжээг Нийслэлийн Аялал жуулчлалын газраас зохион байгууллаа. 06 дугаар сарын 19-25-ны өдрүүдэд хооронд зохион байгуулагдсан тус арга хэмжээнд Нийслэлийн Засаг даргын Хүний хөгжил, нийгмийн бодлогын асуудал хариуцсан орлогч Ш. Анхмаа тэргүүтэй төлөөлөгчид, Нийслэлийн Улаанбаатар чуулга ОНӨҮГ болон аялал жуулчлалын салбарт бизнес эрхлэгчдээс бүрдсэн 60 хүний бүрэлдэхүүнтэй оролцлоо.

Өдөрлөг арга хэмжээний хүрээнд Улаанбаатар хот болон ӨМӨЗО-ны Ордос хотуудын удирдлагууд соёл, аялал жуулчлалын салбарт хамтран ажиллах санамж бичигт гарын үсэг зуран хамтын ажиллагааг өргөжүүллээ.

ӨМӨЗО-ны Ордос хот

Ордос хотын Соёл, аялал жуулчлалын танхимтай хамтран Улаанбаатар хотын аялал жуулчлалыг сурталчлах өдөрлөг хэмжээг 06 дугаар сарын 20-нд зохион байгуулсан ба арга хэмжээний хүрээнд Улаанбаатар хот болон ӨМӨЗО-ны Ордос хотуудын удирдлагууд соёл, аялал жуулчлалын салбарт хамтран ажиллах санамж бичигт гарын үсэг зуран хамтын ажиллагааг өргөжүүллээ.


Арга хэмжээний үеэр Нийслэлийн Улаанбаатар чуулга БНХАУ-ын ӨМӨЗО-ны Ордос хотын их театрт болон Чингисийн онгоны их театрт Ордос хотын олон нийтэд зориулан Монгол үндэсний урлагийн тоглолт хийв.

ӨМӨЗО-ны Улаанцав хот

ӨМӨЗО-ны Улаанцав хотод Монгол, Орос, Хятад гурван улсын аялал жуулчлалын сайд нарын дөрөвдүгээр хуралдаан зохион байуулагдсан ба энэхүү арга хэмжээнд Монгол Улсаас Байгаль орчин аялал жуулчлалын яамны төрийн нарийн бичгийн дарга Ц.Цэнгэл, Гадаад харилцааны яамны Азийн асуудал хариуцсан зөвлөх н.Ганбаатар болон Нийслэлийн Засаг даргын Хүний хөгжил, нийгмийн бодлогын асуудал хариуцсан орлогч Ш. Анхмаа нар тэргүүлэн оролцлоо. Гурван улсын аялал жуулчлалын сайд нарын дөрөвдүгээр хуралдааны үеэр “Цайны зам” олон улсын аялал жуулчлалын холбооны шинэ гишүүн элсүүлэх ёслолын арга хэмжээ зохион байгуулагдсан ба Монгол Улсаас Өмнөговь аймаг болон Сүхбаатар аймгууд тус холбоонд элсэн гишүүний үнэмлэхээ хүлээн авлаа. Хурлын дараа Монгол, Орос,

Хятад гурван улсын уран бүтээлчдийн хамтарсан тоглолт зохион байгуулагдсан ба Нийслэлийн Улаанбаатар чуулгын уран бүтээлчид тоглолтод өөрсдийн уран бүтээлийг толилуулав. Монгол, Орос, Хятад гурван улсын аялал жуулчлалын сайд нарын дөрөвдүгээр хуралдааны хүрээнд аялал жуулчлалын бизнес эрхлэгчдийн экспо зохион байгуулагдсан ба Монгол Улсаас Морнинг Глори” ХХК, “Юнайтед экспресс” ХХК, “Өнөр говь” ХХК, “Ворлд Класс травел” ХХК, “Говь Мираж” ХХК, “Чингисийн тоонт” ХХК, “Түмэн хишигтэн” ХХК, “Талын эзэн” ХХК, “Манжуурын аялал” ХХК, “Маяара” ХХК зэрэг тур оператор компаниуд оролцлоо.

Арга хэмжээний зураг





“СИТИ ТУР” ТӨСЛИЙГ ХЭРЭГЖҮҮЛЖ БАЙНА

“Сити тур” хотын автобустай аяллыг 5 сарын 27-ны өдрөөс эхлүүлсэн бөгөөд одоогийн байдлаар 54 удаагийн аялалд 2163 хүнийг хамруулж 10.297.487 төвлөрүүлсэн байна.





Хоёр: Гадаад, дотоодын жуулчдыг гэмт хэрэг, зөрчилд өртөхөөс урьдчилан сэргийлэх, аюулгүй орчинд зорчих, аялах нөхцөлийг бүрдүүлэх чиглэлээр

“ОЮУТАН ЦАГДАА” ХӨТӨЛБӨР

Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрт Нийслэл Улаанбаатар хотыг гадаадын жуулчинд ээлтэй, аялагч, жуулчид тав тухтай аялах нөхцөлийг бүрдүүлсэн хот болгох зорилтыг дэвшүүлсэн билээ. Энэ ажлын хүрээнд Нийслэлийн Аялал жуулчлалын газар, Нийслэлийн Цагдаагийн газар, Монголын Оюутны Холбоотой хамтран “Оюутан цагдаа-2019” арга хэмжээг жуулчны улирлын хугацаанд /6,7,8-р сард/ их, дээд сургуулийн 40 оюутныг хамруулан 6 дахь жилдээ зохион байгуулж, 2019 оны 08 дугаар сарын 12-ны өдөр ажлаа дүгнэлээ.





Энэ жилийн “Оюутан цагдаа-2019” арга хэмжээг зохион байгуулахдаа нийслэлийн дүүргүүд дэх цагдаагийн хэлтсүүдээс санал авч Сүхбаатар, Чингэлтэй, Баянгол, Баянзүрх, Хан-Уул дүүргийн нутаг дэвсгэр, “Чингис хаан” олон улсын нисэх онгоцны буудал, Улаанбаатар хотын Төмөр зам /вокзал/-ын орчмын худалдаа, үйлчилгээний төв, гадаадын жуулчид ихээр зорчдог, дамжин өнгөрдөг, хөл хөдөлгөөн ихтэй газруудад эргүүлийн 20 чиглэлд 40 оюутан цагдаа 312 цагийн эргүүлийн үүрэг гүйцэтгэв.



“Оюутан цагдаа” нар жуулчдад мэдээлэл сэрэмжлүүлэг, зөвлөгөө өгөх, хууль тогтоомжийг сурталчлах, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр 6 төрлийн 4153 ширхэг санамж, сэрэмжлүүлэг тарааж, гадаадын 11224, дотоодын 92881 иргэнд эрх зүйн туслалцаа, зөвлөгөө үзүүлж, гэмт хэрэг, зөрчлийн 176 мэдээ, мэдээллийг цагдаагийн байгууллагад өгч, эцэг, эх, асран хамгаалагчаасаа төөрсөн 6 хүүхдийг цагдаагийн байгууллагад хүлээлгэн өгч ажиллахаас гадна Үндэсний их баяр наадам, Дээлтэй Монгол наадам, Наадам найт жуулчдад зориулсан арга хэмжээ, БНТУ-ын Үндэсний их хурлын дарга Мустафа Шентопын айлчлал зэрэг арга хэмжээний үеэр цагдаагийн албан хаагчдын бүрэлдэхүүнд орж ажиллав.



“Оюутан цагдаа” О.Номун Э.Анхбаяр нар нь 2019 оны 8 дугаар сар 02-ны өдөр Зайсан толгой орчимд эргүүлийн үүрэг гүйцэтгэж байхдаа Бүгд найрамдах Солонгос улсын иргэн Гу Кихёг цүнхтэй эд зүйлсээ алдсан, Оросын холбооны улсын Анна Руденик тээврийн хэрэгслээ хайгаад олохгүй байсныг олж өгч харьяа дүүрэг дэх цагдаагийн хэлтсийн жижүүрийн бүрэлдэхүүнд тус тус хүлээлгэн өгсөн.



Мөн Оюутан цагдаагийн үйл ажиллагаанаас Бүгд найрамдах Солонгос улсын Сөүлийн их сургуулийн оюутан залуус туршлага судалж ажиллав.

Цагдаагийн Ерөнхий Газрын Урьдчила...

Өнөөдөр /2019.08.09/ Нийслэлийн цагдаагийн газарт тус хөтөлбөрийн үйл ажиллагаатай БНСУ-ын University of Seoul сургуулийн оюутан залуус танилцаж, туршлага судаллаа.



Оюутан цагдаа-2019 арга хэмжээнд амжилттай орлцсон оюутнуудыг Нийслэлийн Аялал жуулчлалын газар, Нийслэлийн Цагдаагийн газар, Монголын оюутны холбооноос шагнаж урамшуулав. Арга хэмжээ хэрэгжих хугацаанд Нийслэл хотын хэмжээнд оюутан цагдаа ажиллах эргүүлийн чиглэлд гадаадын иргэдээс үйлдсэн гэмт хэрэг бүртгэгдээгүй урьд оны мөн үетэй харьцуулахад 3 нэгжээр буюу 3 дахин, мөн гэмт хэрэгт өртөж хохирсон иргэн 2018 оны мөн үеийнхээс 4 нэгжээр буюу 40.2 хувиар тус тус буурсан, гудамж, талбай, олон нийтийн газарт гадаадын иргэд, жуулчдаас гэмт халдлагад өртөж хохирсон тохиолдол 2 бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад ижил түвшинд бүртгэгдсэн үзүүлэлттэй байна.

НИЙСЛЭЛИЙН ЦАГДААГИЙН ГАЗАРТАЙ ХАМТРАН ЗӨВЛӨГӨӨН ЗОХИОН БАЙГУУЛАВ.

Сүүлийн жилүүдэд Нийслэлийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа аялал жуулчлалын үйлчилгээний байгууллагуудад гэмт хэрэг, зөрчил гарах нь нэмэгдэж байгаатай холбогдуулан тэдний үйл ажиллагаанд тавих хяналт тавих, хууль эрх зүйн орчныг сайжруулах зорилгоор Нийслэлийн Цагдаагийн газар, Нийслэлийн Аялал жуулчлалын газар, Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газар хамтран “Дэн болон зочид буудлын үйл ажиллагаанд хяналт тавих ажлыг сайжруулах нь” сэдэвт хэлэлцүүлгийг 2019 оны 05 дугаар сарын 21-ний өдөр Нийслэлийн Цагдаагийн газрын хурлын танхимд зохион байгууллаа.



Хэлэлцүүлэгт дүүргүүдийн засаг даргын орлогч, хүнс худалдаа үйлчилгээний хэлтсийн дарга, мэргэжилтэн, дүүрэг дэх цагдаагийн хэлтсүүдийн урьдчилан сэргийлэх ажил хариуцсан ахлах мэргэжилтэн зэрэг 40 гаруй ажилтнууд оролцож, тулгамдаж байгаа асуудлаа хэлэлцлээ. Хэлэлцүүлгээс аялал жуулчлалын үйлчилгээ эрхэлж байгууллагуудын удирдлагуудтай уулзалт хийх, зөвшөөрөлгүй үйл ажиллагаа явуулж байгаа байгууллагуудын үйл ажиллагааг зогсоох, стандарт журам, хууль эрх зүйн орчныг сайжруулах чиглэлээр Нийслэлийн Засаг дарга, Иргэдийн төлөөлөгчдийн хурал, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн хэмжээнд ажлын хэсэг байгуулж ажиллах, аялал жуулчлалын үйлчилгээний байгууллагуудад хамтран нэгдсэн шалгалт хийж ажиллахаар боллоо.

НАЛАЙХ ДҮҮРГИЙН 6 ДУГААР ХОРООНЫ НУТАГ ДЭВСГЭРТ МОРЬ, ТЭМЭЭН ҮЙЛЧИЛГЭЭ ЭРХЛЭГЧ ИРГЭДТЭЙ УУЛЗАЛТ ХИЙЖ, СУРГАЛТ ЗОХИОН БАЙГУУЛАВ.

Улаанбаатар хотын бүсэд ердийн хөсгийн аяллыг дэмжих, гадаадын жуулчин, иргэдийн эрэлт хэрэгцээнд нийцсэн аяллын бүтээгдэхүүн, үйлчилгээг хөгжүүлж, нүүдлийн соёл иргэншлийг өвлөх, түгээн дэлгэрүүлэх, энэ үйлчилгээг эрхлэх иргэд, аяллын хөтөч нарт тулгамдаад байгаа асуудлыг шийдвэрлэх зорилгоор Налайх дүүргийн Засаг даргын тамгын газар, Нийслэлийн Аялал жуулчлалын газар хамтран 2019 оны 8 дугаар сарын 13-ны өдөр Налайх дүүргийн 6 хорооны нутаг дэвсгэрт морь, тэмээн үйлчилгээ эрхэлдэг иргэдтэй уулзалт хийж, сургалт зохион байгууллаа. Уулзалтад Нийслэлийн Аялал жуулчлалын газрын орлогч дарга Ц.Энхтүвшин, Налайх дүүргийн ЗДТГ-ын ХТНҮ-ний хэлтсийн дарга Ц.Тунгалаг, Налайх дүүргийн Цагдаагийн хэлтсийн урьдчилан сэргийлэх хэлтсийн ахлах мэргэжилтэн, хошууч Б.Батбилгүүн, Налайх дүүргийн 6 дугаар хорооны засаг дарга Ц.Болд болон морь, тэмээн үйлчилгээ эрхэлдэг 5 цэгийг төлөөлж, 40 гаруй иргэд оролцов. Тухайн нутаг дэвсгэрт 90 гаруй морь, тэмээн үйлчилгээ эрхлэгчид үйл ажиллагаа явуулдаг. Энд Налайх дүүргийн оршин суугч иргэдээс гадна залгаа оршдог Төв аймгийн Эрдэнэ сумын иргэд ихэнх хувийг эзэлж үйлчилгээ эрхэлдэг байна. Эдгээр иргэдийн хоорондын үл ойлголцол, хүнээ булаацалдах, хоорондоо ёс зүйгүй, соёлгүй, бүдүүлэг авирлах, хөтөчтэй муудалцах, доромжлох зэрэг нь жижиг гэлтгүй гадаадын жуулчдад муухай харагдаад зогсохгүй, айх, эвгүй сэтгэгдэл төрүүлээд байна. Саяхан 8 дугаар сард Мэлхий хад орчмын морь, тэмээн үйлчилгээ эрхэлдэг иргэд хүнээ булаацалдаж хоорондоо зодолдоод зогсохгүй, хөтчөө зодсон, гадаадын жуулчинг түлхэж унагаасан зэрэг, энэ төрлийн гомдол, санал удаа дараа гарч, хэрэг зөрчлийн тоо нэмэгдээд байгаа.

Уулзалтаар цаашид морь тэмээн үйлчилгээ эрхлэгчдийг хууль эрх зүй, харилцаа хандлага, жуулчны аюулгүй байдал, хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангаж ажиллах сургалтад хамруулж, үйлчилгээ эрхлэх гэрээ байгуулан

бүртгэлжүүлэх, нөхөрлөл хэлбэрээр нэгдсэн зохион байгуулалтад оруулах, үйлчилгээний мэдээлэл, үнэ тарифыг нэгдсэн байдлаар тогтоох, ил тод байршуулах болон саравч, сандал зэрэг тохижилт, хогны асуудлыг дүүрэг хариуцан ажиллах, үйлчилгээ эрхлэгчдэд цагдаагийн хэсэг хяналт тавьж ажиллахаар боллоо.



Уулзалтын үеэр морь тэмээн үйлчилгээ эрхлэгчдэд жуулчны аюулгүй байдлыг хангаж ажиллах, хууль эрх зүйн талаар сургалт зохион байгуулж, Нийслэлийн Аялал жуулчлалын газраас батлан гаргасан “Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт ердийн хөсгөөр аялах, аялуулах зөвлөмж”-ийг танилцуулж, гарын авлага болгон өглөө.

АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫГ ХӨГЖҮҮЛЭХЭД ЖОЛООЧ МИНИЙ ҮҮРЭГ ЧУУЛГАНД ОРОЛЦОВ

Аялал жуулчлалын жолоочдын холбоо нарын холбоо ТББ-аас “Аялал жуулчлалыг хөгжүүлэхэд жолооч миний гүйцэтгэх үүрэг” жуулчин тээврийн жолоочдын анхдугаар чуулга уулзалтыг 2019 оны 5 дугаар сарын 21-ний өдөр Төрийн ордны их танхимд зохион байгуулав. Чуулганд нээлтэд Монгол Улсын ерөнхий сайд У.Хүрэлсүх, БОАЖ-н сайд Н.Цэрэнбат, ЗТХ-н сайд Б.Энх-Амгалан, Нийслэлийн засаг даргын орлогч Ж.Батбаясгалан, АТҮТ-н захирал П.Дэлгэрнаран, Нийслэлийн Аялал жуулчлалын газрын дарга Д.Батсүх нар оролцов. 67 байгууллагын 600 гаруй жолооч оролцсон анхдугаар чуулганаар жуулчин тээврийн салбарын өнөөгийн байдал, тулгамдаж буй асуудал, шийдвэрлэх арга зам, цаашид хийгдэх ажлууд зэрэг асуудлыг төр хувийн хэвшлийнхэн хамтран хэлэлцсэн юм. Хэлэлцүүлэгт тус газрын дарга Д.Батсүх жуулчин тээврийн талаар нийслэлд хэрэгжүүлж байгаа ажил, чуулганд оролцогчдын асуултад хариулж, мэдээлэл өглөө.



Гурав. Аялал жуулчлалын салбарын хөгжлийн чиг хандлага, үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх чиглэлээр

ЗОЧИД БУУДАЛ, ДЭН БУУДАЛ, ЖУУЛЧНЫ БААЗ, АМРАЛТЫН ГАЗРУУДАД ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОВ.

Зочид буудал, дэн буудлын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөлтэй холбоотой эхний хагас жилийн байдлаар 652 албан хүсэлт ирснээс зөвшөөрөл авсан зочид буудлын тоо 236, дэн буудлын тоо 189, жуулчны бааз 25, жуулчны бааз 8 байна. Стандартын шаардлага хангаагүй 276 аж ахуйн нэгжид заавар зөвлөмж өгч ажиллав.

ЖУУЛЧИН ТЭЭВРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОВ.

Нийслэлийн Засаг даргын 2015 оны Улаанбаатар хотын авто замын ачааллыг зохицуулах нэмэлт зарим арга хэмжээ авах тухай А/469 дүгээр захирамжийн дагуу Жуулчин тээврийн үйлчилгээний 8-аас дээш хүний суудалтай зөвшөөрөл бүхий автобусанд улсын дугаарын хязгаарлалтгүй замын хөдөлгөөнд оролцуулах зөвшөөрлийг 31 аялал жуулчлалын байгууллагын 760 автомашинд олгов.

НАЛАЙХ ДҮҮРЭГТ ҮЙЛ АЖИЛЛАГАА ЯВУУЛДАГ АМРАЛТЫН ГАЗРУУДЫГ БҮРТГЭЛЖҮҮЛЖ, СУДАЛГААНД ХАМРУУЛАВ.

Нийслэлийн Засаг даргын 2019 оны Ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх талаар авах зарим арга хэмжээний тухай А/329 дүгээр захирамжийн дагуу Нийслэлийн ногоон бүсэд амралт, аялал зугаалга, төгсөлтийн баярын арга хэмжээ зохион байгуулахыг хориглож, иргэдийн явган болон тээврийн хэрэгслээр ногоон бүсэд нэвтрэх хөдөлгөөнд хяналт тавьж, хөдөлгөөнт эргүүл ажиллуулах, амралт, аялал жуулчлалын газруудтай хамтран иргэдийг ногоон бүсэд нэвтрүүлэхгүй байх, урьдчилан сэргийлэх чиглэлээр “Зөвлөмж”, НИТХ-ийн 2011 оны 120 дугаар тогтоолоор батлагдсан “Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт аялал жуулчлалын байр сууцны үйл ажиллагаа эрхлэх журам”-ын дагуу үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл авч ажиллах “Мэдэгдэл”-ийг тус газрын даргын 2019 оны 01/161 тоот албан бичигт

хавсарган Нийслэлийн Налайх дүүрэгт үйл ажиллагаа явуулдаг 182 амралт, жуулчны баазад хүргүүлж, бүртгэлжүүлэн судалгаанд хамруулав.

ИРГЭНИЙ НИСЭХИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ХАРЬЯА НИСЭХ БУУДЛУУДЫН УДИРДАХ ГАЗАРТАЙ ХАМТРАН АЖИЛЛАХ ГЭРЭЭ БАЙГУУЛАВ.

Иргэний нисэхийн ерөнхий газрын харьяа Нисэх буудлуудын удирдах газартай хамтран ажиллах санамж бичгийг 2019 оны 05 дугаар сарын 28-ны өдөр байгуулсан. Санамж бичгийн хүрээнд Улаанбаатар хотод ирж буй дотоод, гадаадын иргэд, жуулчдад аялал жуулчлалын маркетинг сурталчилгааг хийх, аюулгүй зорчих нөхцлөөр хангах зорилгоор Жуулчны мэдээллийн төв ажиллуулах, такси болон автобусны үйлчилгээг нэвтрүүлэх, зорчигч, жуулчидтай харилцдаг албан хаагчдыг харилцаа хандлагын сургалтад хамруулах, чиглэлээр хамтран ажиллахаар болов.



МҮОНТ-ТЭЙ ХАМТРАН АЖИЛЛАХ САНАМЖ БИЧИГ БАЙГУУЛАВ.

Нийслэлийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг Аялал жуулчлалын газар Монголын Үндэсний Олон Нийтийн Радио Телевизтэй 2019 оны 05 дугаар сарын 23-ны өдөр хамтран ажиллах санамж бичгийг байгуулав. Энэ үеэр Нийслэлийн Аялал жуулчлалын газрын дарга Д.Батсүх Монгол Улсын Засгийн газраас аялал жуулчлалын салбарын хөгжлийг эрчимжүүлж, нийгэм, эдийн засгийн үр өгөөжийг нэмэгдүүлэх замаар 2020 он гэхэд нэг сая гадаадын жуулчин хүлээн авах зорилт тавьсан. Монгол Улсад ирэх жуулчдын дайран өнгөрөх болон зорьж ирэх төв цэг нь Улаанбаатар хот байх болно. Тиймээс аялал жуулчлалын салбарын арга хэмжээ, төсөл хөтөлбөрийг олон нийтэд болон гадны иргэд, жуулчдад хүргэхэд МҮОНРТ-тэй хамтран ажиллахаар боллоо.



Санамж бичгийн хүрээнд талууд Улаанбаатар хотын түүх, соёл, аялал жуулчлалыг дотоод гадаадын үзэгч, сонсогчдод мэдээлэх, эх орон даяар сурталчлан таниулахаар харилцан тохиролцов.

Дөрөв. Салбарын хүний нөөцийг чадавхжуулах чиглэлээр сургалт зохион байгуулах ажлын хүрээнд:

“ХӨТӨЧ, ТАЙЛБАРЛАГЧДЫН УР ЧАДВАР, ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН МЭДЛЭГИЙГ ДЭЭШЛҮҮЛЭХ НЬ” СУРГАЛТ ЗОХИОН БАЙГУУЛАВ.

Жуулчны идэвхтэй улирал эхэлж байгаатай холбогдуулан нийслэлийн Гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөл, Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, нийслэлийн Аялал жуулчлалын газар, Мэргэжлийн хөтөч, тайлбарлагчдын холбоо хамтран 5 дугаар сарын 11, 12-ны өдрүүдэд “Хөтөч, тайлбарлагчдын ур чадвар, хууль эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх нь” сэдэвт сургалтыг анх удаа зохион байгуулж, гадаад, дотоодын жуулчдад Улаанбаатар хотыг эерэгээр, зөв тайлбарлах, жуулчдын аюулгүй байдлыг хангах, гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх, хууль эрх зүйн анхан шатны мэдлэг, мэдээллийг 80 хөтөч, тайлбарлагчдад олгов.



САЛБАРЫН АЖИЛТНУУДЫГ АЖИЛ МЭРГЭЖИЛ ТУС БҮРЭЭР МЭРГЭШҮҮЛЭХ СУРГАЛТ ЗОХИОН БАЙГУУЛАВ.

БОАЖЯ-ны санхүүжилтээр 21 аймаг, Улаанбаатарын бүсэд “Зочлох үйлчилгээний төрөлжсөн сургалт”-ыг 2019 оны 05-р сарын 20-ноос 06-р сарын 20-ны өдрүүдэд зохион байгуулав. Тус сургалтын Улаанбаатар бүсийн сургалтыг нийслэлийн Аялал жуулчлалын газар, дүүргүүдийн Засаг даргын Тамгын газар, Монголын зочид буудлуудын холбоо хамтран явуулж нийслэлийн 9 дүүргийн зочлох үйлчилгээний байгууллагуудын 9 мэргэжлээр нийт 500 гаруй хүн, жуулчидтай харилцдаг төрийн байгууллагуудад зориулсан харилцаа хандлагын сургалтад 600 гаруй хүнийг хамруулав.



НИЙСЛЭЛИЙН ЗАЛУУ ХӨТӨЧ БЭЛТГЭХ СУРГАЛТ ЗОХИОН БАЙГУУЛАВ.

Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Ажлын алба, Нийслэлийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг Аялал жуулчлалын газар, Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар хамтран гадаад хэлний зохих мэдлэгтэй оюутан, залуучуудыг аялал жуулчлалын салбарт хөдөлмөр эрхлэхэд дэмжлэг үзүүлэх, тэдний мэдлэг, ур чадварыг нэмэгдүүлэх зорилгоор 3 дахь жилдээ “Нийслэлийн

залуу хөтөч” сургалтыг 2019 оны 06-р сарын 17-20-ны өдрүүдэд Нийслэлийн Иргэний танхимд амжилттай зохион байгуулав.



“Нийслэлийн Залуу хөтөч” сургалтад нийт 313 залуус бүртгүүлж, 227 залуус 2019 оны 06-р сарын 19-ний өдөр батламжаа гардан авсан. Амжилттай суралцсан залуучуудаас сургалтын агуулгын хүрээнд эссэ болон тестээр шалгалт авч өндөр оноо авсан 90 залуусыг “Сити тур” хотын автобустай аялалд 2019 оны 06 дугаар сарын 20-ны өдөр хамруулж, мэргэжлийн хөтөч, тайлбарлагчидтай хамтран Улаанбаатар хотын түүх, соёлын дурсгалт газруудын танилцах дадлага хичээлийг зохион байгууллаа.

ХЯНАСАН: ХЭЛТСИЙН ДАРГА

Д.ГАНБОЛД

ТАЙЛАН БИЧСЭН: АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН

Э.МӨНХЗУЛ